



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТООЦОО СУДАЛГАА, САНАЛД ҮНДЭСЛЭЖ
ТӨЛӨВЛӨН, ХУУЛЬ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛЖ, ХЯНАЛТЫГ ҮР
ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА БАЙНА.

АУДИТЫН КОД: ГАА-2025/27-6-ШТА-ГА

Газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
Аудитор Г.Энхдэлгэр
Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn
Аудитор С.Санчирмаа
Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
Аудитор О.Энхтөр
Утас: 95343496 Цахим хаяг: enkhuro@audit.gov.mn
Аудитор Г.Булган
Утас: 80920029 Цахим хаяг: bulgang@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/25

Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Говь-Алтай аймгийн Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн газар, Татварын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, биелэлтийг тайланд заасан хугацаанд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Говь-Алтай аймгийн Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Цагдаагийн газар, Татварын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (М.Атарцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.



ГГҮНЖИДМАА

• 822501000055

АГУУЛГА

БҮЛЭГ А. ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ САНАЛ, СУДАЛГАА МЭДЭЭЛЭЛГҮЙГЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА. . 7	
БҮЛЭГ Б. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДААС НОГДУУЛСАН 314.6 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГО ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙНА. 12	12
БҮЛЭГ В. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРДЛЫН 13.7 ХУВИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ. 17	17
БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД АЙМАГ, СУМДЫН ИТХ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА, БУСАД ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА. 19	19
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 24	24



Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1. Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	7
Хүснэгт 2. Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 3. НД-ын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл.....	8
Хүснэгт 4. Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	9
Хүснэгт 5. Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн судалгаа	12
Хүснэгт 6. Эрх бүхий албан тушаалтны судалгаа.....	13
Хүснэгт 8. Торгуулийн орлогын зардлын хуваарилалт.....	16
Хүснэгт 9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөө, гүйцэтгэл	17

Дүрслэлийн товъёг

Дүрслэл №1. Сумдын хүү, торгуулийн орлогын 2024 оны гүйцэтгэл.....	10
Дүрслэл №2. Аймгийн хүү, торгуулийн орлогын 2023, 2024 оны гүйцэтгэл	13

**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх**

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА
ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материал, аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс, Цэргийн штаб, Хилийн цэргийн 214 дүгээр анги, Цагдаагийн газар, Татварын газар, Онцгой байдлын газар, Гадаадын иргэн харьяатын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Төрийн архивын газар, Нийгмийн даатгалын газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар, Байгаль орчны газар, Авто тээврийн төв, Боловсролын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтан, байгууллагуудын холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-3200-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3 Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3 Төрийн аудит, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор М.Атарцэцэг, аудитор Г.Энхдэлгэр, С.Санчирмаа, О.Энхтөр, Г.Булган, Р.Золзаяа нар баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 8 дугаар сарын 08-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2025 оны 8 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр гүйцэтгэж аудитын тайланг 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан байна.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна.

Говь-Алтай аймагт зөрчил хянан шийдвэрлэх 32 байгууллагын 298 эрх бүхий албан тушаалтан 2023 онд 25,919 зөрчилд 1,214.5 сая төгрөгийн торгууль, 2024 онд 28,735 зөрчилд 1,250.9 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

Аймгийн хэмжээнд торгуулийн орлого 2023 онд 1,861.0 сая төгрөгөөр тасарч, 2024 онд 28.2 сая төгрөгөөр давуулж биелсэн байна.

Хүснэгт 1. Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, + тасарсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, + тасарсан
1	Алтай	5.0	5.1	(0.1)	5.0	4.3	0.7
2	Баян-Уул	8.0	8.0	(0.0)	4.0	3.0	1.0
3	Бигэр	5.0	8.3	(3.3)	3.0	2.0	1.0
4	Бугат	2.4	4.5	(2.1)	4.8	2.0	2.8
5	Дарив	6.3	8.54	(2.2)	6.5	6.0	0.5
6	Дэлгэр	5.0	11.6	(6.6)	9.0	13.3	(4.3)
7	Жаргалан	-	2.7	(2.7)	-	0.8	(0.8)
8	Тайшир	2.0	1.9	0.1	2.0	2.0	0.0
9	Тонхил	5.0	1.7	3.3	-	1.0	(1.0)
10	Төгрөг	4.0	5.1	(1.1)	14.0	14.5	(0.5)
11	Халиун	3.0	3.0	0.0	1.5	0.9	0.6
12	Хөхморьт	3.0	1.6	1.4	2.0	4.9	(2.9)
13	Цогт	5.5	6.0	(0.5)	0.5	0.8	(0.3)
14	Цээл	4.0	4.2	(0.2)	4.0	1.7	2.3
15	Чандмань	3.0	3.6	(0.6)	3.0	3.5	(0.5)
16	Шарга	10.6	10.8	(0.2)	7.7	6.8	0.8
17	Эрдэнэ	5.8	7.1	(1.2)	2.8	14.1	(11.3)
18	Есөнбулаг	400.0	416.9	(16.9)	327.0	333.1	(6.1)
19	Гуулин тосгон	1.0	0.1	0.9	1.0	0.2	0.8
20	Баянтоорой тосгон	4.0	1.2	2.8	-	1.0	
	Сумын дүн	482.6	511.9	(29.2)	397.8	416.1	(17.2)
21	Аймаг	2,820.5	930.3	1,890.2	1,286.0	1,297.0	(11.0)
	нийт дүн	3,303.2	1,442.2	1,861.0	1,683.8	1,713.1	(28.2)

БҮЛЭГ А. ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ САНАЛ, СУДАЛГАА МЭДЭЭЛЭЛГҮЙГЭЭР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.

А.1 Хүүгийн орлогын эх үүсвэрийг тодорхой болгож, төлөвлөж байх шаардлагатай байна.

1.1 Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалын хавсралт “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.4.1¹, 1.4.10², 1.4.11³,

¹ Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалын хавсралт “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын 1.4.1-т “төсвийн мэргэжилтнүүд нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг орлого бүрдүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусган, орлогын нэр төрөл тус бүрээр олон жилийн динамик судалгаа, холбогдох мэдээлэлд үндэслэн, орлогод нөлөөлөх хүчин зүйлсийг тооцож, үндэслэлтэй боловсруулах

² 1.4.10-т “төсвийн орлого бүрдэлтэд хяналт тавих, төсвийн орлого төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйлийн талаарх мэдээллийн баазыг төсвийн орлогын нэр төрлөөр, татвар төлөгч байгууллагаар, татвар ногдох зүйлээр тус тус бэлтгэн боловсруулах, мэдээллийн баазыг тухай бүр шинэчлэх, удирдлагад танилцуулах”,

³ 1.4.11-т “төсвийн орлого бүрдүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах”,

1.4.12⁴-т төсвийн мэргэжилтнүүд нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг орлого бүрдүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгах, мэдээллийн баазыг тухай бүр шинэчлэх, төсвийн орлого бүрдүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах зэрэг чиг үүргийг заасан байна.

1.2 Хүүгийн орлогыг төлөвлөхдөө Улсын Их Хурлын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтийг төлүүлэхээр тооцож 2023 онд 779.8 сая төгрөгөөр, 2024 онд 418.2 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Орлогын эдийн засгийн ангиллын тайлбар"-т хүүгийн орлогыг "Тодорхой төрлийн санхүүгийн хөрөнгө эзэмшигч нь санхүүгийн хөрөнгийг эсвэл бусад нөөцийг өөр нэгж этгээдийн мэдэлд шилжүүлсний төлөө авах хүүгийн орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

1.3 Аймгийн хэмжээнд 2023, 2024 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх хүүгийн орлогын эх үүсвэр тодорхойгүй, зээлийн эргэн төлөлтөөр төлөвлөснөөр хүүгийн орлого тасрах шалтгаан болжээ.

Хүснэгт 2. Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлого	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, +Тасарсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, +Тасарсан
Аймаг	779.8	-	779.8	418.2	-	418.2
Сумд	-	-	-	-	-	-
Дүн	779.8	-	779.8	418.2	-	418.2

1.4 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т Нийгмийн даатгалын сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 1.1.1.даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл; ... 11.1.7.хуульд заасан бусад эх үүсвэр" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэлд хүү тооцож нийгмийн даатгалын санд төвлөрч байгаа ч хүүгийн орлогыг төлөвлөхгүй байна.

Хүснэгт 3. НД-ын сангийн харилцахын хүүгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

Орлого	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, +Тасарсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, +Тасарсан
Нийгмийн даатгалын сан	-	25.8	(25.8)	-	32.0	(32.0)
Дүн	-	25.8	(25.8)	-	32.0	(32.0)

1.5 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын хүүгийн орлогыг орон нутгийн төсвийн орлогоор төлөвлөдөггүй бөгөөд байгууллагын дансанд төвлөрүүлж байна.

1.6 Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн орлогыг сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр Засгийн газрын тусгай

⁴ 1.4.12-т "орон нутаг эдийн засгийн хувьд бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс орлогын нэмэгдэл эх үүсвэрийг судлан улмаар төсвийн орлогын тасралтгүй эх үүсвэрийг бий болох талаар саналаа удирдлагад танилцуулах" гэж заасан байна.

сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу тусгай сангийн дансанд төвлөрүүлэхээр сумдын ИТХ-аар баталж байна.

Илрүүлэлт:

- Улсын Их Хурлын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлтийг орлогын эдийн засгийн ангилал зөрчин 2023 онд 779.8 сая төгрөгөөр, 2024 онд 418.2 сая төгрөгөөр хүүгийн орлогоор төлөвлөсөн.

1.7 Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1-т “Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ” гэж заасан бөгөөд торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2⁵-т тусгасан байна.

1.8 Орон нутгийн төсвийн орлогод торгуулийн орлогыг аймгийн ИТХ-ын тогтоолоор 2023 онд 3,303.2 сая төгрөг, 2024 онд 1,683.8 сая төгрөгөөр төлөвлөж баталжээ.

1.9 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлүүдэд оногдуулсан торгох шийтгэлээс төсөвт төвлөрүүлсэн орлогын 40-өөс доошгүй хувийг дараагийн төсвийн жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т заасны дагуу “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг замын санд тус тус зарцуулахаар заасны дагуу торгуулийн орлогыг бодитой тооцоо судалгаа, мэдээлэлд үндэслэн төлөвлөх шаардлага байна.

A.2 Торгуулийн орлогыг төвлөрүүлэх эрх бүхий албан тушаалтны санал, судалгаа мэдээлэлгүйгээр орлогыг төлөвлөж байна.

1.10 Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь торгуулийн орлогыг төлөвлөхдөө өмнөх онуудын гүйцэтгэл, тухайн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцдог байна.

1.11 Аймгийн хэмжээнд торгуулийн орлогын төлөвлөгөө сүүлийн 2021, 2022, 2024 онд 101-129 хувийн гүйцэтгэлтэй давж биелсэн, 2023 онд 43.6 хувь буюу 1,861.0 сая төгрөгөөр тасарсан нь тухайн жилд торгуулийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөснийг харуулж байна.

Хүснэгт 4. Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл


Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	- Давсан, +Тасарсан	(сая төгрөг) Хувь
2021	695.1	899.9	(204.8)	129.4
2022	1,221.3	1,462.9	(241.6)	119.7
2023	3,303.2	1,442.2	1,861.0	43.6
2024	1,683.8	1,713.1	(29.3)	101.7

1.12 Аймгийн хэмжээнд сумдын торгуулийн орлогын гүйцэтгэл харилцан адилгүй байна. Тухайлбал Дэлгэр, Төгрөг, Эрдэнэ сум хүү, торгуулийн орлогыг 12.0 сая төгрөгөөс дээш дүнгээр төлөвлөн төвлөрүүлсэн байхад Жаргалан, Тонхил, Халиун, Цогт сум 1.0 сая төгрөгөөс доош дүнгээр төлөвлөн төвлөрүүлжээ. Иймд тухайн сумдад торгууль ногдуулдаг эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлж цаашид анхаарах шаардлага байна.

⁵ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2-т орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

Дүрслэл №1. Сумдын 2024 оны торгуулийн орлогын гүйцэтгэл

(сая төгрөг)



1.13 Хүү, торгуулийн орлогыг ногдуулах эрх албан тушаалтны санал, судалгаа мэдээлэлгүйгээр орлогыг төлөвлөж байна.

Илрүүлэлт:

- Торгуулийн орлогыг ногдуулах эрх албан тушаалтны санал, судалгаа мэдээлэлгүйгээр орлогыг төлөвлөж байна.

1.14 Хоршоо хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн тухайд ханшийн хэлбэлзэл, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарахгүйгээр зээлийн гэрээнд заасан тухайн жилд төлөх хүүг хуваарийн дагуу төлөвлөж байна.

1.15 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, судалгааны дагуу зардлыг урьдчилан тооцохгүйгээр Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн орлогын 40.0 хувийг дараагийн төсвийн жилийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөдөг байна.

1.16 Торгуулийн орлогыг 2022 онд 1,221.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,462.9 сая төгрөгөөр төвлөрсөн байхад 2023 онд торгуулийн орлогыг тооцохдоо өмнөх оны гүйцэтгэлийг үндэслэлгүй нэмэгдүүлж 3,303.2 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 1,861.0 сая төгрөгөөр буюу 43.6 хувиар тасрах шалтгаан болсон байна.

1.17 Санхүү, төрийн сангийн хэлтэс нь 2023, 2024 онд торгуулийн орлогыг төлөвлөхдөө торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтнаас төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл, тооцоо судалгаа, саналыг аваагүй, эх үүсвэрийг бодитой тодорхойлоогүй, хүүгийн орлогын төлөвлөгөөнд хамаарахгүй орлого төлөвлөсөн зэргээс харахад орлогын эх үүсвэрийг үнэн зөв тодорхойлоогүй байна.

A.3 Торгуулийн мөнгөн дүн багатай олон удаагийн торгуулийг хялбараар төлүүлэх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.

1.18 Хүү, торгуулийн орлогыг бүрдүүлэхдээ Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль болон салбарын бодлого, журам, аргачлалуудыг мөрдөж байна. Эдгээр хуулиуд нь ямар ямар зөрчилд торгууль ногдуулах талаар, тус торгуулийн

орлого нь аль бүс нутагт төвлөрөх, хэрхэн төлөвлөж зарцуулахыг заасан нь харилцан уялдаатай бодит хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

- 1.19 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д торгуулийн орлогын "40.0-өөс доошгүй" хувийг, Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 онд батлагдсан 88/152 дугаар тушаалын хавсралт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах" журамд орлогын 40.0 хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд санхүүжүүлэхээр заасан нь хоорондоо зөрчилдөж байна.

Хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 46.1-д заасан торгуулийн орлогын "40.0 -өөс доошгүй" хувийг санхүүжүүлэхээр заасан байхад Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 онд батлагдсан 88/152 дугаар тушаалын хавсралт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журам"-д орлогын 40.0 хувийг санхүүжүүлэхээр заасан нь зөрчилдөж байна.

- 1.20 Хүү тооцох аргачлал, хувь хэмжээг холбогдох журмууд болон гэрээний нөхцөлөөр тодорхойлж байна. Тухайлбал, Хоршоо хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлөлттэй зээлийн хүүг "Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.5.1-д зааснаар жилийн 3 хувиар, арилжааны банканд данстай Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд банкттай байгуулсан гэрээний дагуу хүү тооцож байна. Нэгдсэн хууль эрх зүйн зохицуулалт, тусгайлсан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

- 1.21 Аймгийн хэмжээнд 2023 онд 25,876 торгууль, 2024 онд 28,723 торгууль ногдуулсан байна.

- 1.22 Дээр дурдсан зөрчлөөс бусад зөрчил нь Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйл, заалттай нийцэж, зөрчлийн шинжид тохирсон торгуулийн хэмжээтэй байна.

- 1.23 Аймгийн Прокурорын газраас 2023, 2024 онд Цагдаагийн газрын цахимаар ногдуулснаас бусад аймгийн хэмжээний эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан шийдвэрт хяналт хэрэгжүүлж, торгууль ногдуулах хуулийн заалт нь гарсан зөрчилтэй нийцээгүй бол хүчингүй болгож, шийтгэврийн хуудсанд өөрчлөлт оруулж зөрчлийг хянан шийдвэрлэсэн байна.

- 1.24 Аймгийн Цагдаагийн газрын цахимаар оногдуулж буй торгуулийн арга хэмжээнд иргэн өөрөө гомдол гаргаагүй тохиолдолд Прокурорын байгууллагаас хяналт хэрэгжүүлдэггүй байна.

- 1.25 Аймгийн Цагдаагийн газарт 2017-2022 онд тогтоосон хэв журмын чиглэлээр болон зам тээврийн зөрчил гаргасан насжилт өндөртэй 224.2 сая төгрөгийн 7,204 торгууль төвлөрөөгүй байна. Цахимаар оногдуулсан торгуулийг иргэд төлөхгүй байгаагаас торгуулийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

- 1.26 Төвлөрүүлээгүй торгуулийн 50.0 мянган төгрөгөөс бага дүнтэй торгууль 88.0 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2024 оны А/42, А/71 дугаар тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох, хугацаа, аргачлал"

журмын 2.5-д зааснаар торгууль төлөөгүй этгээдийг оршин суугаа газар нь эсхүл харьяа шүүхэд танилцуулж хүргүүлэх үүргийг шийтгэл оногдуулсан алба хаагч хүлээдэг хэдий ч бага дүнтэй олон тооны торгуулийг нэг бүрчлэн шүүхэд шилжүүлэх боломж нөхцөл хомс харагдаж байгаа тул бага дүнтэй торгуулийг төлүүлэх хөшүүрэг хэрэгтэй байна. Тухайлбал иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ тухайн иргэнд оногдуулсан торгуулийг бүрэн төлсний дараа хэрэгцээт үйлчилгээг үзүүлдэг зохицуулалт шаардлагатай байна.

БҮЛЭГ Б. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУДААС НОГДУУЛСАН 314.6 САЯ ТӨГРӨГИЙН ТОРГУУЛИЙН ОРЛОГО ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙНА.

Б.1 Аймгийн Цагдаагийн газар, Татварын газрын эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.1 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дэх заалтад “...хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум дүүрэг орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар хуульчилсан байна.

2.2 Аймгийн хэмжээнд 2023 онд 25,919 зөрчил илрүүлж, 1,214.5 сая төгрөгийн, 2024 онд 28,735 зөрчил илрүүлж, 1,251.0 сая төгрөгийн торгууль ногдуулжээ. Нийт торгуулийн 70.5 хувийг аймгийн Цагдаагийн газар, 23.0 хувийг Татварын газар, 6.5 хувийг бусад байгууллага ногдуулсан байна. Торгуулийн төлөлт дунджаар 2023 онд 90.7 хувь, 2024 онд 83.8 хувийн биелэлттэй байна.

2.3 Аймгийн Цагдаагийн газар, Татварын газраас бусад байгууллага ногдуулсан торгуулийг бүрэн төвлөрүүлж ажилласан байна.

Хүснэгт 5. Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн судалгаа

(сая төгрөг)

Байгууллагын нэр	Зөрчлийн тоо	2023 он			Зөрчлийн тоо	2024 он		
		Ногдуулсан дүн	Төвлөрүүлсэн дүн	Төвлөрүүлээгүй дүн		Ногдуулсан дүн	Төвлөрүүлсэн дүн	Төвлөрүүлээгүй дүн
ГХБХБГ	4	11.0	11.0	-	22	64.0	64.0	-
Нийгмийн даатгалын газар	7	3.5	3.5	-	0	-	-	-
Улсын бүртгэлийн хэлтэс	339	9.4	9.4	-	149	4.6	4.6	-
Онцгой байдлын газар	5	1.6	1.6	-	5	2.3	2.3	-
Авто тээврийн төв	16	1.3	1.3	-	15	2.0	2.0	-
ЗДТГ	16	2.4	2.4	-	15	22.3	22.3	-
Гадаадын иргэн харьяатын газар	1	0.1	0.1	-	26	2.6	2.6	-
Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар	8	1.8	1.8	-	10	1.4	1.4	-
Хилийн цэргийн 0214 дүгээр анги	0	-	-	-	2	0.4	0.4	-

Аймгийн ЗДТГ-СТСХ	2	0.8	0.8	-	0	-	-	-
Татварын газар	50	349.8	303.0	46.9	42	218.1	128.2	89.9
Цагдаагийн газар	25,428	812.1	746.2	65.9	28,437	927.0	815.1	111.9
БОГ	43	20.8	20.8	-	12	6.4	6.4	-
Нийт	25,919	1,214.5	1,101.7	112.8	28,735	1,251.0	1,049.2	201.8

Дүрслэл №2. Аймгийн хэмжээний 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын төвлөрүүлсэн дүн
(сая төгрөг)



Илрүүлэлт:

- Аймгийн Цагдаагийн газар нь тогтоосон торгуулиас 2023 онд 65.9 сая төгрөг, 2024 онд 111.9 сая төгрөг төвлөрүүлээгүй.
- Аймгийн Татварын газар нь тогтоосон торгуулиас 2023 онд 46.9 сая төгрөг, 2024 онд 89.9 сая төгрөг төвлөрүүлээгүй.

2.4 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д “Дараах эрх бүхий албан тушаалтан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ” гэж заасны дагуу аймгийн хэмжээнд нийт 32 байгууллагын 228 торгох эрх бүхий албан тушаалтан байна. Үүнд: Цагдаагийн газрын 55, Татварын газрын 32, Бургастай дахь Гаалийн хорооны 15, Нийгмийн даатгалын газрын 19, бусад байгууллагын 107 эрх бүхий албан тушаалтан торгууль ногдуулах эрхтэй байна.

2.5 Аймгийн хэмжээнд 2023-2024 онд эрх бүхий 14 байгууллага, 148 албан тушаалтан 54,654 зөрчилд 2,465.4 сая төгрөгийн торгуулийг ногдуулжээ.

Хүснэгт 6. Эрх бүхий албан тушаалтны судалгаа

Д/д	Байгууллагын нэр	Эрх бүхий албан тушаалтны тоо
1	Бургастай дахь Гаалийн хороо	15
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4
3	Улсын бүртгэлийн хэлтэс	1
4	Санхүү, төрийн сангийн хэлтэс	0
5	Сумын Засаг даргын Тамгын газар /Байгаль орчны улсын байцаагч/	11
6	Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа	2

7	Нийгмийн даатгалын газар	19
8	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	1
9	Татварын газар	32
10	Цагдаагийн газар	55
11	Боловсролын газар	1
12	Гадаадын иргэн харьяатын газар	0
13	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	6
14	Онцгой байдлын газар	5
15	Байгаль орчны газар	3
16	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	2
17	Эрүүл мэндийн газар	5
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	4
19	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	1
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	3
21	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	3
22	Мал эмнэлгийн газар	15
23	Авто тээврийн төв	2
24	Төрийн архивын газар	0
25	Стандарт хэмжил зүйн хэлтэс	3
26	Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	1
27	Хилийн цэргийн 0214 дүгээр анги	24
28	Цэргийн штаб	1
29	Говийн их дархан цаазат газрын "А" хэсгийн хамгаалалтын захиргаа	3
30	Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	1
31	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар	1
32	Монгол банк	4
Нийт		228

2.6 Аймгийн хэмжээнд 7 сумын Байгаль орчны улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагч нь улсын байцаагчийн эрхгүй, Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, Авто замын хяналтын улсын байцаагч томилоогүй байна. Энэ нь салбарын хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэлд хариуцлага тооцохгүйгээс гадна торгуулийн орлогын бүрдүүлэлтэд нөлөөлж байна.

2.7 Орон нутгийн төсөвт торгуулийн орлогыг төвлөрүүлдэг эрх бүхий байгууллагуудаас Төрийн архивын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс, Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс, аймгийн ЗДТГ, Цэргийн штаб, Боловсролын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын эрх бүхий албан тушаалтнууд 2023-2024 онд торгууль огт ногдуулаагүй байна.

Илрүүлэлт:

- Аймгийн хэмжээнд 7 сумын Байгаль орчны улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагч нь улсын байцаагчийн эрхгүй, Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, Авто замын хяналтын улсын байцаагч томилоогүй байна. Энэ нь салбарын хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэлд хариуцлага тооцохгүйгээс гадна торгуулийн орлогын бүрдүүлэлтэд нөлөөлж байна.

2.8 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь заалтад “бүх орлого” гэж заажээ. Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайланд торгуулийн орлогыг 2023 онд 3,303.2 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,442.2 сая төгрөг, 2024 онд 1,683.8 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,713.1 сая төгрөг төвлөрүүлснийг ТЭЗ, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн үнэн зөв тусгасан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан байна.

2.9 Аймгийн торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд 1,442.2 сая төгрөг бөгөөд нийт орлогын 2.6 хувийг, татварын бус орлогын 3.7 хувийг эзэлж байна. Харин 2024 онд 1,713.1 сая төгрөг болж, нийт орлогын 42.1 хувийг, татварын бус орлогын 72.4 хувийг бүрдүүлж байгаа нь торгуулийн орлого төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна.

Б.2 Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 16.0 хувь, 2024 онд 20.1 хувиар хуваарилжээ.

2.10 Аймгийн ТЭЗ нь хүү, торгуулийн орлогын хуваарилалтыг хийхдээ орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлээс төлөвлөн, аймгийн ИТХ-д төсвийн саналыг өргөн мэдүүлж, 2023 онд 260.8 сая төгрөгөөр, 2024 онд 289.6 сая төгрөгөөр тус тус батлуулжээ.

2.11 Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 4⁶-т заасны дагуу аймгийн ИТХ-аас сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд тухайн сумын гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан хуваарилалт хийсэн байна.

2.12 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ” гэж торгуулийн орлогын хуваарилалт хийх аргачлалд заасан байна.

2.13 Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийг авто замын санд төвлөрүүлэхээр заасан. Гэтэл Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д “Зөрчлийн тухай хуулийн ...14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7 ... дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай

⁶ Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн жилийн төсвийг батлахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл / цаашид Зөвлөл гэнэ/ -ийн нэрээр тусад нь нэр зааж батлахаас гадна тухайн сум, дүүргийн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан гаргасан хуваарийг үндэслэн сум, дүүрэг тус бүрээр нэр зааж батална. Уг хөрөнгийг сум, дүүргийн батлагдсан төсөв дээр нэмж олгоно

тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ" гэж заасан байгаа нь зөрчилдөж байгаа тул аймаг торгуулийн орлогыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар төлөвлөж, авто замын санд төвлөрүүлэхээр төлөвлөөгүй байна.

Хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох саналыг нэгтгэсэн тайлангаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх:

- Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т "нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль"-ийг авто замын сангийн эх үүсвэр байхаар заасан байхад Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Зөрчлийн тухай хуулийн 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ" гэж заасан байгаа нь зөрчилдөж байна.

2.14 Аймгийн ИТХ-аас аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд 260.8 сая төгрөг, 2024 онд 289.6 сая төгрөгийг баталсан байна. Сумдад хуваарилахдаа хүн ам, зөрчлийн тоог харгалзаж баталжээ.

Хүснэгт 7. Торгуулийн орлогын зардлын хуваарилалт

№	Аймаг, сумын нэр	2022 оны торгуулийн орлогын гүйцэтгэл	2023 оны зардлын төлөвлөгөө	Зардлын хуваарилалт хувь	2023 оны торгуулийн орлогын гүйцэтгэл	2024 оны зардлын төлөвлөгөө	(сая төгрөг) Зардлын хуваарилалт хувь
1	Аймгийн ИТХ	1,203.5	131.0	10.9	930.3	150.9	16.2
2	Алтай	7.0	3.3	47.0	5.1	-	0.0
3	Баян-Уул	6.0	3.5	58.5	8.0	11.3	140.8
4	Бигэр	7.0	7.3	104.7	8.3	8.2	99.2
5	Бугат	2.7	1.5	56.0	4.5	-	0.0
6	Дарив	5.9	2.5	41.8	8.5	8.7	101.4
7	Дэлгэр	11.5	19.4	168.4	11.6	16.4	141.5
8	Жаргалан	1.7	0.6	35.4	2.7	0.5	18.6
9	Тайшир	2.0	1.0	48.5	1.9	0.8	41.8
10	Тонхил	4.3	0.9	21.2	1.7	1.1	65.5
11	Төгрөг	8.9	0.5	5.6	5.1	1.7	33.4
12	Халиун	4.3	6.6	155.2	3.0	7.9	264.0
13	Хөхморьт	5.4	2.0	37.0	1.6	1.5	94.0
14	Цогт	8.1	8.6	106.1	6.0	9.9	164.7
15	Цээл	3.8	0.5	12.5	4.2	1.6	38.0
16	Чандмань	3.0	1.2	39.9	3.6	1.4	40.0
17	Шарга	6.2	0.2	3.2	10.8	0.2	1.8
18	Эрдэнэ	3.7	0.3	8.2	7.1	1.0	14.1
19	Есөнбулаг	335.3	70.0	20.9	416.9	66.4	15.9
	Нийт	1,630.2	260.8	16.0	1,440.9	289.6	20.1

2.15 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 46.1-д заасан торгуулийн орлогын "40-өөс доошгүй" хувийг санхүүжүүлэхээр тусгасан байхад 2023 онд нийт орлогын 16.0 хувь буюу 260.8 сая төгрөг, 2024 онд 20.1 хувь буюу 289.6 сая төгрөгийг баталжээ. Харин торгуулийн орлогоос авто замын санд хуваарилаагүй байна.

2.16 Гадаадын иргэн харьяатын газар, Цагдаагийн газар, Татварын газар, Онцгой байдлын газар, Нийгмийн даатгалын газар, аймгийн ЗДТГ-ын торгууль ногдуулсан эрх бүхий албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ тухайн албан хаагчийн гаргасан шийтгэлийн биелэлт, төвлөрүүлсэн орлогын хэмжээг гол шалгуур болгон ашиглаж, гүйцэтгэлийн тайланд тусган үнэлж байна.

2.17 Дээр дурдсанаас бусад эрх бүхий албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийн хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогын үзүүлэлтийг албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ харгалзан үздэггүй, гүйцэтгэлийн тайланд тусгадаггүй байна.

БҮЛЭГ В. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРДЛЫН 13.7 ХУВИЙГ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛЖЭЭ.

В.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 13.7 хувийг үр ашиггүй зарцуулжээ.

3.1 ГХУСАЗСЗ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2023 онд 4 бүлгийн хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 260.8 сая төгрөг, 2024 онд 3 бүлгийн хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 289.6 сая төгрөгийн төсөв батлуулжээ.

3.2 ГХУСАЗСЗ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж 2023 онд 239.4 сая төгрөг, 2024 онд 221.1 сая төгрөг зарцуулж, зарцуулаагүй 90.0 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөө, гүйцэтгэл

(сая төгрөг)

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Алтай	3.3	3.3	-	-	-	-
2	Баян-Уул	3.5	2.3	1.2	11.3	8.7	2.6
3	Бигэр	7.3	6.3	1.0	8.2	6.2	2.0
4	Бугат	1.5	0.4	1.1	-	-	-
5	Дарив	2.5	2.3	0.2	8.7	7.4	1.3
6	Дэлгэр	19.4	18.4	1.0	16.4	6.9	9.5
7	Жаргалан	0.6	0.3	0.4	0.5	0.4	0.1
8	Тайшир	1.0	1.0	-	0.8	0.8	-
9	Тонхил	0.9	0.9	0.0	1.1	1.1	0.0
10	Төгрөг	0.5	0.4	0.1	1.7	1.4	0.3
11	Халиун	6.6	6.6	-	7.9	7.9	-
12	Хөхморьт	2.0	2.0	0.0	1.5	1.2	0.3
13	Цогт	8.6	8.0	0.6	9.9	2.1	7.7
14	Цээл	0.5	0.5	0.0	1.6	1.6	-
15	Чандмань	1.2	1.2	0.0	1.4	1.4	-
16	Шарга	0.2	-	0.2	0.2	0.2	0.0
17	Эрдэнэ	0.3	0.2	0.1	1.0	0.5	0.5
18	Есөнбулаг	70.0	69.5	0.5	66.4	66.1	0.3
	Сумын дүн	129.8	123.5	6.3	138.6	113.9	24.7
19	Аймаг	131.0	115.8	15.2	150.9	107.1	43.8

нийт дүн	260.8	239.4	21.5	289.6	221.1	68.5
----------	-------	-------	------	-------	-------	------

3.3 Хүү, торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлийг үзэхэд 2023 онд зориулалтын дагуу 196.5 сая төгрөг, 2024 онд 200.9 сая төгрөгийг олон нийтийн цагдаагийн цалин, урамшуулал, тоног төхөөрөмж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл хийх зэрэг зардлуудад зарцуулсан байна.

3.4 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг зөрчиж 63.0 сая төгрөг буюу төсвийн 13.7 хувийг үр ашиггүй зарцуулсан. Үүнд:

- Хэвлэлийн зардалд 1.0 сая төгрөг,
- Цайны материал, хоолны зардалд 7.0 сая төгрөг,
- Шүүхийн Тамгын газарт автомашин бэлтгэхэд 34.9 сая төгрөг,
- Мэдүүлэг өгөх өрөөний засварын ажилд 15.0 сая төгрөг,
- ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаатай холбоогүй шатахууны зардалд 2.9 сая төгрөг.

Илрүүлэлт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023 онд Шүүхийн Тамгын газарт автомашин 34.9 сая төгрөг, Баруун бүсийн аймгуудын ИТХ-ын Ажлын албаны албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтад 8.0 сая төгрөг, 2024 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдүүлэг өгөх өрөөний засварын ажилд 15.0 сая төгрөг, “ГХУССЗ-ийн Баруун бүсийн уулзалт, зөвлөгөөн”-ний шатахууны зардалд 2.9 сая төгрөг, тэмцээн, шагнал, урамшуулалд 2.2 сая төгрөг, нийт 63.0 сая төгрөгийг тус тус үр ашиггүй зарцуулсан байна.

3.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу аймгийн ИТХ-ын төсөвт 82201 кодтой зориулалт, арга хэмжээгээр батлагдаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна. Сумдын салбар зөвлөл нь сумын ЗДТГ-ын төсөвт мөн адил ангиллаар батлагдаж зарцуулсан.

3.6 Аудитаар зардлын гүйцэтгэлийг шалгахад ангилал хооронд зарцуулсан алдаа, зөрчил илрээгүй болно.

3.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр олон нийтийг хамарсан дараах арга хэмжээг зохион байгуулжээ. Үүнд:

- ГХУСАЗСЗ болон хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах нэгдсэн сургалтад 194 иргэнийг хамруулжээ,
- Согтуугаар үйлдэгдсэн болон зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг хүргэх чиглэлээр олон талт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж 88 хүүхэд, 105 сурагч, 588 иргэнд сургалт мэдээлэл хийж, 4,800 брошюрыг тараасан,
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 18 удаа сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлжээ,
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр 12,450 иргэнийг хамруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан,

- Шинэсэн ой бүхий сумдад эргүүл хяналт шалгалт явуулж 60 иргэнд гарын авлага тараан, мэдээлэл хүргүүлжээ.

3.8 Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, сургалт мэдээлэл хүргэх нь иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аргад суралцах, хууль эрх зүйн мэдлэг олгох зорилготой мөн нийгэм эдийн засагт учрах хор хөнөөлийг буруулах, гэмт хэргийн гаралт буурах үндэс болно.

3.9 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх нийгэмд нөлөө үзүүлэх зорилгоор Цагдаагийн газарт уян камер, драгер, цагдаагийн албан хаагчдын шалгах төхөөрөмжийн эрх сунгах, Байгаль орчны газарт хээрийн ажлын тоног төхөөрөмж, Онцгой байдлын газарт зургийн аппарат, Шүүхийн тамгын газарт компьютер, тоног төхөөрөмж нийлүүлжээ.

B2. Хүү торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлжээ.

3.10 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэж заасан.

3.11 Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 5.0 сая төгрөгөөс дээш мэдээлбэл зохих 2023 онд 79.4 сая төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй, 2024 онд 55.4 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлээгүй зөрчилд 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэр хүргүүлж, биелүүлжээ.

3.12 Аймаг, сумдын ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийн зарцуулалтыг шилэн дансны цахим сайтаар мэдээлж, ил тод байдал, олон нийтийг хяналт тавих боломжоор ханган ажиллаж байна.

3.13 ГХУСАЗСЗ нь 2023, 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээлэл, зарцуулалтын тайланг “Алтай телевиз”, “Миний Алтай телевиз”, аймгийн Цагдаагийн газрын цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хийжээ.

3.14 Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөлөөс аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалттай холбоотой ил тод байдалд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

БҮЛЭГ Г. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД АЙМАГ, СУМДЫН ИТХ, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА, БУСАД ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Г.1 Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангүй байна.

4.1 Улсын хэмжээнд зөрчил, торгууль, шийтгэлийн мэдээллийг нэгтгэн бүртгэх, байгууллага хооронд мэдээлэл солилцох, орлого бүрдүүлэлтийн хэрэгжилтийг хянах мэдээллийн нэгдсэн сангүй байна. Байгууллага бүр өөрийн салбарын программ хангамжийг ашиглаж, зарим газарт бүртгэлийн цахим сан үүсгээгүй байна.

4.2 Хяналт хэрэгжүүлэх байгууллага, эрх бүхий албан тушаалтан хоорондын мэдээлэл солилцох, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахад мэдээллийн цахим систем хөгжүүлэх шаардлагатай байна.

- 4.3 Татварын газар, Стандарт хэмжил зүйн газар, Цагдаагийн газар нь байгууллагын дотоод системээрээ дамжуулан ногдуулсан торгууль, торгуулийн төвлөрүүлэлтийг хянадаг. Бусад байгууллага нь торгууль шийтгэлийн цахим системийг үйл ажиллагаандаа ашиглахгүй байна.
- 4.4 Хүү, торгуулийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлж торгуулийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих шаардлагатай байна.
- 4.5 Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын газар, Цагдаагийн газар нь Ebarimt.mn, Emongolia.mn, torguuli.mn зэрэг төлбөрийн хялбаршуулсан системийг ашигладаг, бусад байгууллагууд арилжааны банкуудын төлбөрийн цахим систем ашиглаж байна.
- 4.6 Байгууллагууд дотоод системээрээ дамжуулан хяналт хэрэгжүүлж, тухайн торгуулийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Г.2 Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймаг, сумдын ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, бусад хөндлөнгийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

- 4.7 Цагдаагийн байгууллагын 2017-2022 оны хугацаанд 7204 иргэнд ногдуулсан 224.2 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлээгүй, олон жил болсон төлөгдөөгүй торгуулийг төвлөрүүлэх, хяналт тавьж дараагийн шатанд шилжүүлэх арга хэмжээ аваагүй байна.
- 4.8 Торгуулийн орлого бүрэн төвлөрөөгүй шалтгааныг судлан, нөхөн барагдуулах болон шаардлагатай арга хэмжээг авах талаар дараагийн шатны зохион байгуулалт, хяналтын ажиллагаа хангалтгүй байгаа нь орлого дутуу төвлөрөхөд нөлөөлсөн байна.
- 4.9 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5.1⁷- дэх заалтын дагуу дараа дараагийн арга хэмжээ авч ажиллавал хуулийн хэрэгжилт хангагдах, торгуулийн орлого нэмэгдэх үр нөлөөтэй.

Илрүүлэлт:

- Аймгийн Цагдаагийн газраас 2023 оноос өмнө тогтоосон торгуулиас 224.2 сая төгрөг бүхий 7204 торгууль хэрэгжээгүй үлдэгдэлтэй байна.

- 4.10 Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалын хавсралт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах" журмын 12-т "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын байгуулалт, зарцуулалтад тухайн шатны Хурал, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавина." гэж заасан боловч хүү,

⁷ Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна", 8-д "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана", Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал"-ын 2.4-т "Энэ аргачлалын 2.2-т заасан хугацаа дуусмагц эрх бүхий албан тушаалтан дараах шийдвэрийг гаргаж, харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ: Үүнд 2.4.2-т "Хүнд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр нь 450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс доош бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх хүсэлт

торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

- 4.11 Төрийн аудитын байгууллагаас аймгийн ИТХ-ын 2023, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлтэй холбоотой илэрсэн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.
- 4.12 Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Татварын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Гадаадын иргэн харьяатын газар, Төрийн архивын газар, Нийгмийн даатгалын газарт Ерөнхий газрын дотоод хяналтын газраас хүү, торгуулийн ногдуулалт, бүрдүүлэлтэд тус тус хяналт хэрэгжүүлсэн байна.
- 4.13 Хүү,торгуулийн орлогод иргэд, төрийн бус байгууллагаас хяналт хийгээгүй байна. Харин Төрийн аудитын байгууллагаас орон нутгийн 2023, 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд санал дүгнэлт өгөх аудитаар хүү, торгуулийн орлогын төлөвлөлтөд, мөн онуудын санхүүгийн тайлангийн аудитаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад аудит хийсэн.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүүгийн орлогын эх үүсвэрийг тодорхой болгож, төлөвлөж байх шаардлагатай байна.
2. Торгуулийн орлогыг төвлөрүүлэх эрх бүхий албан тушаалтны санал, судалгаа мэдээлэлгүйгээр орлогыг төлөвлөж байна
3. Торгуулийн мөнгөн дүн багатай олон торгуулийг хялбараар төлүүлэх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.
4. Аймгийн хэмжээнд 7 сумын Байгаль орчны улсын байцаагч, Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж буй албан хаагч нь улсын байцаагчийн эрхгүй, Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, Авто замын хяналтын улсын байцаагч томилоогүй байна.
5. Аймгийн Цагдаагийн газар, Татварын газрын эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын 13.7 хувийг үр ашиггүй зарцуулжээ.
7. Хүү торгуулийн орлогын зарцуулалтыг ил тод мэдээлжээ.
8. Хүү, торгуулийн орлогын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангүй байна.
9. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад аймаг, сумдын ИТХ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, бусад хөндлөнгийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ ТООЦОО СУДАЛГАА, САНАЛД ҮНДЭСЛЭЖ ТӨЛӨВЛӨН, ХУУЛЬ ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ТӨВЛӨРҮҮЛЖ, ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА БАЙНА.

Аудитаар 377.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, аймгийн Засаг даргад 1 зөвлөмж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 1 зөвлөмж, Цагдаагийн газарт 1 зөвлөмж, Татварын газарт 1 зөвлөмж хүргүүлж, нэгдсэн тайланд тусгуулах 2 саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжиллаа.

ЗӨВЛӨМЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

- Авто зам, гадаадын иргэн, нягтлан бодох бүртгэл, архив, албан хэрэг хөтлөлт, байгаль орчны хяналтын чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг улсын байцаагчийн эрхтэй болгох арга хэмжээ авч ажиллах.

АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ

- Хүүгийн орлогыг Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Орлогын эдийн засгийн ангиллын тайлбар"-ын дагуу үнэн зөв төлөвлөх
- Хүү, торгуулийн орлогыг ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас орлогын төлөвлөгөөний санал, судалгаа авч төсвийн төслийг боловсруулж, төлөвлөх

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛД

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хууль журмын хүрээнд үр ашигтай зарцуулах

ЦАГДААГИЙН ГАЗАРТ

- Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллах

ТАТВАРЫН ГАЗАРТ

- Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллах

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ САНАЛ

Хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх.

- Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т "нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль"-ийг авто замын сангийн эх үүсвэр байхаар заасан байхад Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Зөрчлийн тухай хуулийн 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-оос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ" гэж заасны дагуу орон нутагт торгуулийн орлогыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төлөвлөн зарцуулж байгаа нь зөрчилдөж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 46.1-д заасан торгуулийн орлогын "40.0 -өөс

доошгүй" хувийг санхүүжүүлэхээр заасан байхад Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 онд батлагдсан 88/152 дугаар тушаалын хавсралт "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журам"-д орлогын 40.0 хувийг санхүүжүүлэхээр заасан нь нийцэхгүй байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг 82093
Утас/Факс 7048-4042, Цахим шуудан info@govi-altai.gov.mn
Цахим хуудас www.govi-altai.gov.mn

2025.08.22 № 8/1169

танай _____-ны № _____-т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт
зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын
асуудлын бүртгэл, тайлантай танилцлаа.
Тайлантай холбоотой санал байхгүй болно.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.ХАШ-ЭРДЭНЭ



D:Ajl.hettes.CTCH / A-5

ТЭМДЭГЛЭЛ